



НИЙСЛЭЛИЙН ТАТВАРЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2019 03 01

012

оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

"Тэд констракшн" ХХК-ийн гомдлын тухай

Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн хуралдааныг Д.Сайханчулуун даргалж, гишүүд Б.Болормаа, Б.Баттогтох, Б.Төгслхам, С.Туяасайхан, нарийн бичгийн дарга Ж.Эрдэнэбүрэн нарын бүрэлдэхүүнтэй, "Тэд констракшн" ХХК-аас Баянгол дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2018 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 260011875 дугаар шийтгэлийн хуудсанд гаргасан гомдлыг, тус компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Сүхбаатар, Баянгол дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ц.Төгсбаяр, Б.Оюунцэцэг нарыг оролцуулан магадлагч-татварын улсын байцаагч Г.Ганбат магадлагаа хийж, танилцуулснаар хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ НЬ:

1. "Тэд констракшн" ХХК-ийн захирал А.Эрдэнэ нь Татварын маргаан таслах зөвлөлд ирүүлсэн гомдолдоо, "Манай компанийн 2012.01.01-нээс 2012.12.31-нийг дуусталх хугацааны татварын ногдуулалт, төлөлтийн байдалд Баянгол дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч нар хэсэгчилсэн татварын хяналт шалгалт хийж, 2012 онд "Далайдорж" ХХК-аас 0012975058 тоот падаанаар 44,272700.0 төгрөг, 0012975150 тоот падаанаар 47,545,500.0 төгрөг, 0012975149 тоот падаанаар 52,454,500.0 төгрөг, "Дархан наран сүлд" ХХК-аас 0012354144 тоот падаанаар 181,818,200.0 төгрөг, "Цэцэгт рашаан" ХХК-аас 0012358952 тоот падаанаар 234,381,800.00 төгрөг нийт 761,654,500.00 төгрөгийн нэмэгдсэн өртгийн хий бичилттэй падаан бүхий худалдан авалтыг үндэслэлгүй гэж үзэн, төлбөрийн акт болгон ногдуулсан байна.

2012 оны зөрчилд 2018 оны 03-р сарын 22-ны өдөр шийтгэл тогтоосон нь хөөн хэлэлцэх хугацаа дууссан байна. Өөрөөр хэлбэл Татварын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт "Татвар нөхөн ногдуулах, алданги, торгууль ногдуулах хөөн хэлэлцэх хугацаа 5 жил байх бөгөөд Монгол Улсын Иргэний хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа татварын хууль тогтоомжид хамаарахгүй" гэж заасныг зөрчсөн тул хүчингүй болгож өгнө үү" гэсэн гомдлыг гаргасан байна.

2. Татварын улсын байцаагч Ц.Төгсбаяр, Б.Оюунцэцэг нар тайлбартаа: "Баянгол дүүргийн Татварын хэлтэстэй харьцдаг 2627566 тоот регистрийн дугаартай "Тэд констракшн" ХХК-ийн 2012 оны 01 сарын 01-нээс 2012 оны 12 сарын 31-ийг дуусталх хугацааны татварын ногдуулалт төлөлтийн байдалд 2013 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 220074 тоот татварын улсын байцаагчийн дүгнэлт, Нийслэлийн Баянгол дүүргийн прокурорын газрын 2016 оны 07 сарын 18-ны өдрийн 1524 тоот тогтоолыг үндэслэн 22/130220 тоот "Татварын хяналт шалгалт хийх томилголт", "Татварын хяналт шалгалт хийх ерөнхий удирдамж"-ийн дагуу Баянгол дүүргийн татварын хэлтсийн

татварын улсын байцаагч бид 2017 оны 03 сарын 20-ны өдрөөс 12 дугаар сарын 06-ны өдрүүдэд хэсэгчилсэн хяналт шалгалт хийж, 2018 оны 03 сарын 22-ны өдөр 260011875 дугаар шийтгэлийн хуудсаар 761,654,500.00 төгрөгийн зөрчилд 76,165,450.00 төгрөгийн нөхөн татвар ногдуулсан

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.1-т заасны дагуу "Тэд констракшн" ХХК-тай холбогдох хэргийг Нийслэлийн Баянгол дүүргийн Прокурорын газрын 2016 оны 07 сарын 18-ны өдрийн 1524 тоот прокурорын тогтоолоор 761,654,500.0 төгрөгийн хий бичилттэй падаанаар хий бичилт хийсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн... тул хэрэгсэхгүй болгосон..." шийдвэр гаргасан байна.

2 Баянгол дүүргийн Прокурорын шийдвэрийг үндэслэн татварын улсын байцаагчийн дүгнэлтийг Татварын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т "Энэ хуулийн 33.2 б-д заасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүчингүй болгосон нь зөрчил гаргасан этгээдийг захиргааны хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй" гэж заасны дагуу 2017 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс 2018 оны 3 дугаар сарын 22-ны өдрүүдэд хэсэгчилсэн хяналт шалгалтыг хийж дуусгасан болно.

Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах орлогыг бууруулсан 761,654,500.0 төгрөгийн зөрчилд ногдуулсан 22,849,635.0 төгрөгийн торгууль, 38,082,725.0 төгрөгийн алдангийг чөлөөлсөн болно." гэж тэмдэглэсэн.

3. Магадлагч-татварын улсын байцаагч Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журмын 6 дугаар зүйлд заасан эрх, үүргийн дагуу оролцогч талуудаас ирүүлсэн гомдол, тайлбар, татварын болон санхүүгийн тайлан, анхан шатны баримт, журналын бүртгэл зэрэг холбогдох материалд тулгуурлан Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журмын 3 дугаар зүйл болон бусад хууль тогтоомжид үндэслэн магадлагаа хийж, татварын улсын байцаагчийн 260011875 дугаар шийтгэлийн хуудсаар 76,165,450.0 төгрөгийн татвар нөхөн төлүүлэхээр шийдвэрлэснийг хүчингүй болгуулах гэсэн саналыг оруулсан.

ҮНДЭСЛЭХ НЬ:

Татвар төлөгч татварын улсын байцаагчийн 260011875 тоот шийтгэлийн хуудсаар 1 төрлийн 761,654,500.0 төгрөгийн зөрчил илрүүлж 76,165,450.0 төгрөгийн нөхөн татвар бүгд 76,165,450.0 төгрөгийн төлбөр ногдуулсныг эс зөвшөөрч гомдол гаргасан.

2012 онд 761,654,500.0 төгрөгийн хий бичилттэй худалдан авалтыг нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд хасалт хийж төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татварыг бууруулсан зөрчил нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 14 дүгээр зүйлийн 14.3 дах заалтуудыг зөрчсөнийг тэмдэглээд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, Татварын ерөнхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.3 дах заалтаар хариуцлага тооцож, "Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 10 дугаар зүйлийн 10.7-д заасны дагуу хариуцлагыг өршөөлд хамруулж шийдвэрлэсэн байна.

Татвар төлөгч хөөн хэлэлцэх хугацаа дууссан, хууль зүйн үндэслэлгүй байх тул зөвшөөрөх боломжгүй гэж маргасан.

2627566 дугаар регистрийн дугаар бүхий барилгын засвар үйлчилгээ, барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг "Тэд констракшн" ХХК нь 2012 онд "Далайдорж" ХХК-аас 0012975058 тоот падаанаар 44,272,700.0 төгрөг, 0012975150 тоот падаанаар 47,545,500.0 төгрөг, 0012975149 тоот падаанаар 52,454,500.0 төгрөг, "Дархан наран сүлд" ХХК-аас 0012354144 тоот падаанаар 181,818,200.0 төгрөг, "Цэцэгт рашаан" ХХК-аас 0012358952 тоот падаанаар 234,381,800.0 төгрөг нийт 761,654,500.0 төгрөгийн барилгын бараа материал худалдан авалт хийгдсэнээр хий бичилттэй

нэмэгдсэн өртгийн албан татварын падаан бичүүлэн авч нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт төлөлтийн тайлангийн "нэмэгдсэн өртгийн албан татвартай үнээр дотоодын зах зээлээс худалдан авсан бараа" хэсэгт тусгаж худалдан авалтын хасалт хийж төсөвт төлөх албан татварыг бууруулж, 2012 оны 5, 11, 12 сарын нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгасан цахим тайлангийн системд хадгалагджээ.

Цахим тайлангийн бичилтээр нотлогдож буй татварын улсын байцаагчийн шийтгэлийн хуудсанд дурдсан 2012 онд нийт 761,654,500.0 төгрөгийн хий бичилт бүхий худалдан авалтыг 2012 оны 5, 11, 12 сарын нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгасан нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-д "Худалдан авагч нь бэлтгэн нийлүүлэгчид нэмэгдсэн өртгийн албан татвар төлсөн нь нэхэмжлэл, падаан болон нягтлан бодох бүртгэлийн бусад баримтад тусгагдаагүй бол уг албан татварыг хасч тооцохгүй" гэсэн заалтыг зөрчсөн боловч 2018 оны 12 сарын 18-ны өдөр шийтгэлийн хуудсаар захиргааны хариуцлага тооцсон нь Татварын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Татвар нөхөн ногдуулах, алданги, торгууль ногдуулах хөөн хэлэлцэх хугацаа 5 жил байх бөгөөд Монгол Улсын Иргэний хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа татварын хууль тогтоомжид хамаарахгүй", мөн зүйлийн 11.3-г "Энэ хуулийн 11.1-д заасан хөөн хэлэлцэх хугацааг дараахь байдлаар тоолж эхэлнэ. 11.3.2 тайланг сар, улирал бүр гаргаж татвар төлөхөөр хуульд заасан татварын төрлийн хувьд тухайн жилийн 12 дугаар сарын буюу жилийн эцсийн татварын тайлан гаргаж, татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс" буюу нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан сар бүр гардаг бөгөөд жилийн эцэст өссөн дүнгээр тайлан гаргадаггүйгээрээ бусад татвараас онцлог тул хөөн хэлэлцэх хугацааг буруу тоолсон гэдэг үндэслэлээр татварын улсын байцаагчийн шийтгэлийн хуудсыг хүчингүй болгох нь зүйтэй гэж зөвлөлийн бүрэлдэхүүн дүгнэлээ.

Татварын ерөнхий хуулийн 42 дугаар зүйлийн 7 дахь заалтыг удирдлага болгон

ТОГТООХ НЬ:

1. Татварын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 74 дүгээр зүйлийн 74.1, 74.3, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, "Анхны ардчилсан сонгууль болж, байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус баримтлан татварын улсын байцаагчийн үйлдсэн 260011875 дугаар шийтгэлийн хуудсаар 76,165,450.0 төгрөгийн татвар нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн шийтгэлийн хуудсыг бүхэлд нь хүчингүй болгосугай.

2 Шийдвэрийг эс зөвшөөрөөл шийтгэлийн хуудсанд гомдол гаргагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дээд шатны татварын албаны дэргэдэх маргаан таслах зөвлөл болон Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй

ХУРАЛ ДАРГАЛСАН:

Д.САЙХАНЧУЛУУН

ГИШҮҮД:

Б.БОЛОРМАА

Б.БАТТОГТОХ

Б.ТӨГСЛХАМ

С.ТУЯАСАЙХАН

Ж.ЭРДЭНЭБҮРЭН